



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 46

Мандалговь

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын  
сонгон шалгаруулалт зохион байгуулах  
комисс томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3.2, 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга: Р.Мөнхтогтох – (Салбар зөвлөлийн гишүүн, Аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор)

Гишүүд:  
Б.Мөнхбат -(Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Цагдаагийн газрын дарга)

А.Лхагвасүрэн- (Салбар зөвлөлийн гишүүн, Аймгийн Шүүхийн тамгын газрын дарга)

С.Адъяасүрэн – (Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн ерөнхий нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: С.Хулан -(Салбар зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

2. “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-д заасан сонгон шалгаруулах комиссын чиг үүргийг хэрэгжүүлж шалгалтын бэлтгэлийг ханган зохион байгуулж, холбогдох мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг комисс (Р.Мөнхтогтох)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ

